

УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗАР, ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх явцад төрийн захиргааны байгууллага, аж ахуй нэгжийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар заалтыг үндэслэн энэхүү журмыг боловсруулсан болно.

1.3. Журмыг хэрэгжүүлэх ажлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хариуцан зохион байгуулна.

Хоёр. Нэр томъёоны ойлголт

2.1. Жуулчний бааз гэдэгт аялал жуулчлалын бүс нутагт жуулчдыг тав тухтай амрах, зугаацуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй танилцуулах зорилго бүхий үйлчилгээний цогцолборыг ойлгоно.

2.2. Амралтын газар гэдэгт иргэдийг үзэсгэлэнт байгальд алжаалаа тайлах, тав тухтай амрах орчинг бүрдүүлсэн цогцолборыг ойлгоно.

2.3. Зочид буудал гэдэгт зочдыг хүлээн авч байр, хоол бусад үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний цогцолборыг ойлгоно.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоод, гадаадын өмчийн бүх хэлбэрийн жуулчны баазууд, амралтын газрууд, гурваас доош одны зэрэглэл бүхий зочид буудлууд, дэн буудлууд, гэйст хаусууд болон бусад хоноглох байрны үйлчилгээ эрхэлж байгаа газрууд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

3.2. Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт харъяалагдах тусгай хамгаалттай газар нутагт үйл ажиллагаа явуулах жуулчны бааз, амралтын газар, зочид буудал энэхүү журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

Дөрөв. Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага

4.1. Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан нөхцөлд үйлчилгээ эрхлэнэ.

4.1.1. Зочид буудлын ажил үйлчилгээ эрхлэгч нь хуулийн этгээд байна.

4.1.2. Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага, стандартыг 85-аас доошгүй хувиар хангасан байна.

4.1.3. Зочид буудлын барилгын зураг төсөлд баталгаажилт хийлгэж, улсын комисст хүлээлгэж өгсөн байна.

4.1.4 Зочид буудлын менежмент, марктенгийн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж, үнэмлэх, гэрчилгээ авсан менежер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдаар хангагдсан байна.

4.2. Жуулчны бааз, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан нөхцөлд үйлчилгээ эрхлэнэ.

4.2.1. Жуулчны баазын ажил үйлчилгээ эрхлэгч нь хуулийн этгээд байна.

4.2.2. Газар эзэмших болон байгаль орчны тухай хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан байна.

4.2.3. Жуулчны бааз, амралтын газрын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага, стандартыг 85-аас доошгүй хувиар хангасан байна.

4.2.4. Үйлчилгээ явуулах барилга байгууламжийн зураг төсөлд баталгаажилт хийлгэж, улсын комисст хүлээлгэж өгсөн байна.

4.2.5. Аялал жуулчлалын болон зочид буудлын менежмент, марктенгийн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж, үнэмлэх, гэрчилгээ авсан менежер, техникийн ажилтан, мэргэжлийн ажилчдаар хангагдсан байна.

Тав. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

5.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйлчилгээ эрхлэхэд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авна.

5.1.1. Энэхүү журмын 4.1, 4.2-д заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгж байгууллагад зөвшөөрлийг олгоно.

5.2. Уг зөвшөөрлийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын тушаалаар өгөх бөгөөд дээрх шаардлагыг хангаж зөвшөөрөл авсныг батламжилсан гэрчилгээг тухайн дүүргийн Засаг даргын Тамгын газар олгоно.

5.3. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тухайн ажлын байранд үйлчлүүлэгчдэд харагдахуйц газарт эх хувиар нь байрлуулж ажиллана.

Зургаа. Зөвшөөрөл олгох.

6.1. Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрөл авах хүсэлтээ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аялал жуулчлалын хэлтэст албан бичгээр гаргах буюу онлайн үйлчилгээгээр ирүүлж болно.

6.2. Зочид буудлын зөвшөөрөл авахыг хүссэн албан бичиг /эрхлэх үйл ажиллагааны төрөл, оноосон нэр, оршин байрлах хаяг, харилцах утас, онлайн хаягийг тодорхой бичих/-т дараах баримт бичгийг хавсаргана.

6.2.1. Зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар,

6.2.2. Зочид буудлын үйлчилгээний стандартыг хэрхэн хангаж байгаа тухай мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт,

6.2.3. Зочид буудлын барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт.

6.3. Жуулчны бааз, амралтын газрын зөвшөөрөл авахыг хүссэн албан бичиг /эрхлэх үйл ажиллагааны төрөл, оноосон нэр, оршин байрлах хаяг, харилцах утас, онлайн хаягийг тодорхой бичих/-т дараах бичиг баримтыг хавсаргана.

6.3.1. Зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний батаалгаажсан хуулбар,

6.3.2. Газар эзэмших эрхийн актын баталгаажсан хуулбар,

6.3.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,

6.3.4. Жуулчны бааз, амралтын газрын үйлчилгээний стандартыг хэрхэн хангаж байгаа тухай мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт,

6.3.5. Жуулчны бааз, амралтын газрын барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт.

6.4. Зөвшөөрөл олгогч нь зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгжийн албан бичиг, хавсаргасан баримтуудыг хүлээн авч, хянан үзэж, энэхүү журмын шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.

6.5. Зөвшөөрөл олгогч нь хүсэлт гаргасан байгууллагуудын талаар цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг харгалзан үзнэ.

6.6. Зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгоно.

6.7. Зөвшөөрөл олгогч нь хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

6.8. Зөвшөөрөл олгосон шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор жагсаалтыг харъяа дүүрэг, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагад хүргэнэ.

6.9. Зөвшөөрөл олгохоос татгалзсан бол үндэслэлийг тодорхой зааж, бичгээр хариу өгнө.

6.10. Албан бичигт хавсаргасан баримт бичиг нь шийдвэр гаргах шаардлагыг хангаагүй бол дахин тодруулах буюу нэмэгдэл материал гаргуулахаар зөвшөөрөл хүсэгчид буцаана.

6.11. Зөвшөөрөл олгохтой холбогдон гарах зардлыг зөвшөөрөл хүсэгч тал хариуцна.

Долоо. Зөвшөөрлийг сунгах, цуцлах, хяналт тавих

7.1. Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар сунгана.

7.2. Зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ зөвшөөрөл эзэмшигчээс гаргана.

7.3. Зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7.4. Зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн заасан хугацаанд хүчинтэй байх бөгөөд эзэмшигчээс түүний хугацаа дуусахад сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх товлосон он, сар, өдрийн дараагийн ажлын өдөр болмогц дуусгавар болгоно.

7.5. Зөвшөөрлийн хугацааг сунгахад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэнэ.

7.6. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд бүх шатны Засаг дарга, зөвшөөрөл олгосон байгууллагын ажил хариуцсан албан тушаалтан, мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана.

7.7. Зөвшөөрөл эзэмшигч нь шаардлага хангаагүй ажил үйлчилгээ явуулж байгаа нь тогтоогдвол хууль хяналтын байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг түр хугацаагаар буюу бүрэн зогсоох тухай асуудлыг зөвшөөрөл олгогчид бичгээр тавина.

7.8. Зөвшөөрөл олгогч нь дараах тохиолдолд зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө цуцлана.

7.8.1. Хуулийн этгээд татан буугдсан,

7.8.2. Зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээг нэг жилийн хугацаанд эрхлээгүй,

7.8.3. Нийгэм, иргэд, үйлчлүүлэгчдийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд харшилсан ажил үйлчилгээ явуулсан болох нь тогтоогдсон.

7.9. Зөвшөөрлийг тухайн ажлын байр бүрт авна.

7.10. Зөвшөөрлийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аялал жуулчлалын хэлтэс хураан авч цуцлах эрхтэй.

Найм. Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэхэд хориглох зүйлс.

8.1. Зөвшөөрлийг өөр аж ахуйн нэгжид шилжүүлэн хэрэглэх, өөр ажлын байранд ашиглах, арилжаалах,

8.2. Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх явцад үйлчилгээний дэг журамд онцгой анхаарч, хуульд заасан цагийн хуваарийг баримтлан согтуу хүн, 21 нас хүрээгүй хүнд үйлчлэх,

8.3. Биеэ үнэлэх явдлыг дэмжсэн, байраар хангасан, зуучилсан, сурталчилсан, зохион байгуулалттайгаар оролцох, хэрэг зөрчил гаргах нөхцөл бүрдүүлэх,

8.4. Нийтийн орон сууцны суурийн давхарт зочид буудлын үйл ажиллагаа явуулах,

8.5. Хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа явуулах.

Ес. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын эрх үүрэг.

9.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн нутаг дэвсгэрт жуулчны бааз, амралтын газрууд, зочид буудлын ажил үйлчилгээ эрхлэх журмыг батлан гаргаж, биелэлтэнд хяналт тавина.

9.2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

9.2.1. Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах, сурталчилах ажлыг зохион байгуулна.

9.2.2. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангасан байгууллага, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгож, гэрээ байгуулна.

9.3. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар нь дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

9.3.1. Өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах байгууллагуудыг зөвшөөрөлд хамруулах ажлыг зохион байгуулна.

9.3.2. Зөвшөөрөл олгогдсон байгууллагуудад гэрчилгээ олгоно.

9.4. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

9.4.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх жуулчны бааз, амралтын газар, зочид буудлуудын ажлын байртай танилцаж, стандартын шаардлага хэрхэн хангаж байгаа талаар дүгэнлт гаргана.

9.4.2. Зөвшөөрөл авсан жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын үйл ажиллагаанд өөрийн байгууллагын эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

9.4.3. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад хяналт тавьж, холбогдох хуулийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Арав. Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх үүрэг.

10.1. Үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын гаргасан журам заавар, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

10.2. Зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журамд заасан шаардлагыг биелүүлж, эрх үүргээ эдэлнэ.

10.3. Зөвшөөрөл олгогчоос тогтоосон судалгааны маягт үзүүлэлтээр өөрийн үйл ажиллагааны талаар тайлан мэдээг тухайн цаг хугацаанд нь гаргаж ирүүлнэ.

10.4. Зөвшөөрөл эзэмшигч өөрийн эрх, ашиг хөндөгдсөн тохиолдолд хууль, хяналтын байгууллагад хүсэлтээ тавьж, шийдвүүрлүүлэх эрхтэй.

10.5. Зөвшөөрөл хүсэгч нь жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг авахдаа хуулийн дагуу тэмдэгтийн хураамж төлнө.

Арван нэг. Хариуцлага.

11.1. Зөвшөөрөл эзэмшигч нь жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын ажил үйлчилгээ эрхлэх явцдаа гаргасан зөрчилд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

11.2. Зочид буудлын ажил үйлчилгээ явуулахад дагаж мөрдөх хууль тогтоомж болон энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Улсын хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчид хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.3. Энэхүү журмын 7.8-д заасас нөхцөл үүссэн тохиолдолд зөвшөөрөл олгогч зөвшөөрлийг цуцлах буюу хураана.

Арван хоёр. Бусад зүйл.

12.1. Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.